



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/281

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 27 дугаар зүйлийн 27.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, 33 дугаар зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" XIV/01 тогтоол, аймгийн "Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх" сарын аяны хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл, ахуйн зөвлөл, удирдлага, ажилтан, албан хаагчид, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдуулан хууль, дүрэм, журмын мэдлэг, мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулсугай.

2. Сумд, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зөвлөл, ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад шаардагдах 3,245,000 (гурван сая хоёр зуун дөчин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Сум, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл, ахуйн зөвлөл, ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Булган сум, 2023 оны 04 сарын 19 өдөр /А/2023/Захирамж

6323010265

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 19-ны өдрийн А/28 дугаар
захирамжийн хавсралт

СУМД, БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРҮҮЛ, АХУЙН ЗӨВЛӨЛ,
АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

ХООЛ, ЦАЙНЫ ЗАРДАЛ

(сум-85, хэлтэс, агентлаг-20, аж ахуй нэгж, байгууллагын-5, зохион байгуулагч – 5, нийт-
115 ажилтан хамрагдах)

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Бага үдийн цай	Багц (кофе, гамбургер)	115	5,000	575,000
2	Үдийн хоол	Багц (хоол, цай)	115	18,000	2,070,000
3	Сургагч багшийн зардал	4 цаг	1	150,000	600,000
Нийт					3,245,000